



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

“Шад трейд” ХК-ийн нэгдмэл сонирхолтой  
хувьцаа эзэмшигчдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг  
худалдан авахаар гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2, Компанийн тухай хуулийн 57.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Шад трейд” ХК-ийн нийт гаргасан 39,885 ширхэг хувьцааны 74,52 хувь буюу 29,725 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Транс-Рашиан Монголиан холдингс Эс.Эй.Ар.Эл. /Trans Russian-Mongolian Holdings S.A.R.L./, Аня-Эл стратегик Эс.Эй.Ар.Эл /Anya-L strategic S.A.R.L./, Эм.Эс.Эйч холдингс Эс.Эй.Ар.Эл /MSH holdings S.A.R.L./-иудаас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 25,48 хувь буюу 10,160 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 /нэг зуу/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 7 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Шад трейд” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргах ажиллагаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Жеймс Пассин/-д үүрэг болгосугай:

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодексе”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

001616